

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 05 дугаар сарын 21

Улаанбаатар хот

| Д/д  | Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа  | Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан | Цаашид авч хэрэгжүүлэх арга зам | Хувь |
|--|---|--|---------------------------------|------|
| 1  | <p><b>Үүрэг, даалгавар НЭГ:</b> Үүрэг, даалгавар <b>ХОЁР:</b> Нийслэлийн газрын маргаан таслан шийдвэрлэх комиссын ажлыг эрчимжүүлж, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн харьяа байгууллагууд шаардлагатай мэдээллийг шуурхай гаргаж, мэдээллээр хангах</p> <p>Дүүрэг, Нийслэлийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр газар зохион байгуулалт, хариуцсан мэргэжилтэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 4 удаагийн шүүх хуралд оролцож, нотлох баримт, бусад материалыг хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Сэрсэндэмид, Мөнхжаргал нарын нэхэмжлэлтэй тус дүүргийн 23 дугаар хороонд байршилтай газрын маргааны асуудалтай шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, газар эзэмшлийн хувийн хэрэг болон тайлбарыг гаргаж өгсөн шүүх хурал эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.</li> <li>2. Иргэн Д.Янжинхорлоогийн нэхэмжлэлтэй шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхэд тайлбар өгч маргаан бүхий газарт шүүхийн үзлэг хийх ажиллагаанд оролцсон шүүх хурал эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.</li> <li>3. Иргэн Д.Мөнхбаатарын нэхэмжлэлтэй шүүх хуралд оролцож хариу тайлбар гаргаж өгсөн давж заалдах шатанд явж байна.</li> <li>4. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Хулан, Ариунболд, Ц.Сарангэрэл, Ю.Бямбасүх нарын нэхэмжлэлтэй тус дүүргийн 24 дугаар хороонд байршилтай газрын маргаантай асуудалтай шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож газар эзэмшлийн хувийн хэрэг болон тайлбарыг гаргаж өгсөн шүүх хурал эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.</li> </ol> |  |                                 | 100  |
| <p><b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Үүрэг, даалгавар <b>ДӨРӨВ:</b> Нийслэлийн хэмжээнд мод тарих ажлыг зохион байгуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах</p> |   |  |                                 |      |

|                       |  |  |             |
|-----------------------|--|--|-------------|
| 2                     | <p>Дүүргийн засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Хаврын мод тарих аяныг зарлах тухай” А/173 дугаар захирамжийн хүрээнд Шинжиян улиас модыг дүүргийн 13 дугаар хороонд 2500 ширхэг мод тарих, мөн дүүргийн Засаг даргын дэргэдэх 24 байгууллага, 18 сургууль, 38 цэцэрлэг, 1-24 дүгээр хороо, 21 СӨХ зэрэг нийт 125 байгууллагын гадна болон ойр орчмоор 7600 ширхэг мод тарих санал, суулгацын тоо хэмжээний судалгааг авч, 05 дугаар сарын 24-ний өдөр бүх нийтээрээ мод тарихаар болсон. Мөн Баянбүрдийн тойргоос 32-ын тойрог хүртэл 470 ширхэг нарс мод, 32-ын тойргоос 7 буудал хүртэл зам дагуух газрыг ногоон бүс болгох, зүлэгжүүлэх ажлууд хийгдэж байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад орчиндоо мод тарьж, ургуулахыг уриалж, дүүргийн цахим хуудсаар хаврын мод тарих аяныг сурталчилж байна.</p> |  | 100         |
| <b>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</b> |  |  | <b>100%</b> |



ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.БАТЦЭЦЭГ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ

*В. Уранчимег*